



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Монгол Улсын Консерваторийн харъяа Завхан аймаг дахь Хөгжим бүжгийн коллежийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2024/245/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Улиастай сум

2024 он

Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын

дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: [Bat-Undraa@audit.gov.mn](mailto:BatUndraa@audit.gov.mn)

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: Boldbaatarkh@audit.gov.mn

Ахлах аудитор: Ц.Оюунсүвд

Утас: 99076038

Цахим хаяг: oyunsuvdts@audit.gov.mn

Гэрээт аудитор : Ц.Алтантуул

Утас: 91195554

Цахим хаяг: tuul9565@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	11
4. Аудитын тайлан.....	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. Аудитын илрүүлэлт	16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс:7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2024.02.23 № 142

танай _____ -ны № _____ -т

МОНГОЛ УЛСЫН КОНСЕРВАТОРИЙН
ХАРЬЯА ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ХӨГЖИМ БҮЖГИЙН КОЛЛЕЖИЙН
ЗАХИРАЛ Г.АЛТАНЦЭЦЭГ-Т

Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монгол Улсын Консерваторийн харьяа Завхан аймаг дахь Хөгжим бүжгийн коллежийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлсөн бөгөөд өргөн тархсаныг хангалттай, зохистой аудитын нотолгоонд үндэслэн нотолсны улмаас Монгол Улсын Консерваторийн харьяа Завхан аймаг дахь Хөгжим бүжгийн коллежийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй гэж үзсэн.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Монгол Улсын Консерваторийн харьяа Завхан аймаг дахь Хөгжим бүжгийн коллеж нь 2023 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд авлагыг тооцооны үлдэгдлийн баталгаагаар баталгаажуулаагүй, хөрөнгийн ашиглалтын хугацааг оруулаагүйгээс хөрөнгийн элэгдэл бодогдоогүй, хөрөнгийн орлогыг бүртгэхдээ тоо хэмжээ болон үнийн дүнг зөрүүлж бүртгэдэг, бараа материалын хөдөлгөөний бүртгэл буруу хийдэг, оюутнуудын байрны төлбөр болон сургалтын төлбөрийг Удирдах зөвлөлөөр тогтоолгоогүй, хүчингүй тогтоолоор төлүүлж, орлого хүлээн зөвшөөрөлтийг нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт заасны дагуу хийж, хүлээн зөвшөөрдөггүй, суралцагчдын баруун аймгуудаар явсан тайлан тоглолтын орлогыг санхүүгийн тайланд тусгаагүй, хувь хүний дансаар дамжуулан зарцуулсан зэрэг нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-д "аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.5-д "бүх орлого" 14.4.6-д "бүх зардал", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг зөрчиж, тохиолдсон байх, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

013010039

Audit(D)Дүгнэлт/2024

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Консерваторийн харьяа Завхан аймаг дахь Хөгжим бүжгийн коллеж нь нийт 2,059.2 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, зарцуулснаас 1,982.5 сая төгрөгийн орлогыг урсгал үйл ажиллагаанаас, 71.4 сая төгрөгийн орлогыг оюутны сургалтын төлбөр болон байрны төлбөрөөс, 5.3 сая төгрөгийг нэмэлт санхүүжилтээр бүрдүүлсэн байна. Тайлант хугацаанд 37.8 сая төгрөгөөр тоног төхөөрөмж худалдан авсан байна.

Аудитын гол асуудал

Монгол Улсын Консерваторийн харьяа Завхан аймаг дахь Хөгжим бүжгийн коллеж нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар захирлын тушаалыг хавсралтгүйгээр гаргаж, улирлын үр дүнгийн урамшуулал бодож олгосон, илүү цаг, үр дүнгийн урамшууллыг цагийн тооцоо, үндэслэх баримтад тусгасан цаг болон хувиар бодоогүй, илүү тооцож олгосон, 4 дүгээр улирлын үр дүнгийн урамшууллыг шийдвэргүйгээр олгосон зөрчил илэрсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Нягтлан бодох бүртгэлийг аккрузль сууриар бүртгээгүй, зардлын ангиллыг буруу бүртгэсэн, оны эцэст байгууллагуудтай тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан өглөгийг санхүүгийн тайланд тусгаагүй, санхүүгийн тайланд буруу илэрхийлсэн зэрэг алдаа байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан****2023 оны 12 дугаар сарын 31****/төгрөгөөр/**

Дансны код	Блансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	362,615,396.30	386,403,986.07
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	0.00	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	0.00	-
3121	Төгрөг	0.00	-
31211	Төрийн сангийн харилцах	0.00	-
33	АВЛАГА	11,604,548.40	16,537,438.17
33100	Ажиллагсадтай холбогдсон авлага	-	4,932,889.77
335	Бусад авлага	11,604,548.40	11,604,548.40
3352	Хувь хүмүүсээс авах авлага	11,604,548.40	11,604,548.40
35	БАРАА МАТЕРИАЛ	351,010,847.90	369,866,547.90
351	Түүхий эд материал	213,619,067.90	213,619,067.90
35110	Тусгай зориулалттай материал	213,234,067.91	213,234,067.91
35130	Эм боох материал	384,999.99	384,999.99
354	Хангамжийн материал	137,391,780.00	156,247,480.00
35410	Бичиг хэргийн материал	4,652,600.00	19,811,900.00
35420	Аж ахуйн материал	123,753,280.00	127,006,280.00
35450	Барилгын засварын материал	65,500.00	65,500.00
35460	Хүнсний материал	-	443,400.00
35470	Бусад хангамжийн материал	8,920,400.00	8,920,400.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,252,335,469.74	2,153,010,658.40
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,252,335,469.74	2,153,010,658.40
392	Биет хөрөнгө	2,204,655,469.74	2,105,330,658.40
39201	Барилга, байгууламж	2,135,624,630.00	2,135,624,630.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(250,625,376.88)	(311,729,615.92)
39203	Авто тээврийн хэрэгсэл	23,500,000.00	23,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(23,500,000.00)	(23,500,000.00)
39205	Машин, тоног төхөөрөмж	514,265,246.87	552,085,596.87
39206	Хуримтлагдсан элэгдэл	(272,166,303.21)	(323,834,772.31)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	162,983,757.70	162,983,757.70
39208	Хуримтлагдсан элэгдэл	(137,448,303.60)	(161,820,756.80)
39214	Бусад үндсэн хөрөнгө	8,500,000.00	8,500,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(5,312,499.72)	(5,312,499.72)
39217	Номын фонд	48,834,318.58	48,834,318.58
393	Биет бус хөрөнгө	47,680,000.00	47,680,000.00
39301	Програм хангамж	2,150,000.00	2,150,000.00

39302	Хасагдуулга	(2,150,000.00)	(2,150,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	47,680,000.00	47,680,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,614,950,866.04	2,539,414,644.47
4	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	1,275,229.04	34,726,124.08
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,275,229.04	34,726,124.08
413	Өглөг	1,275,229.04	34,726,124.08
41310	Ажиллагчидтай холбогдсон өглөг	39,904.04	39,904.04
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	404,365.04
4136	Бусад өглөг	1,235,325.00	34,281,855.00
41361	Байгууллагад төлөх өглөг	1,235,325.00	29,184,405.00
41362	Хувь хүмүст төлөх өглөг	-	5,097,450.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	2,613,675,637.00	2,504,688,520.39
51	Засгийн газрын хувь оролцоо	2,613,675,637.00	2,504,688,520.39
511	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	1,975,612,137.46	1,975,612,137.46
51101	Өмч: -Төрийн өмч	1,975,612,137.46	1,975,612,137.46
512	Хуримтлагдсан үр дүн	(161,550,971.97)	(270,538,088.58)
51210	Өмнөх үеийн үр дүн	(161,550,971.97)	(161,550,971.97)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(108,987,116.61)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	799,614,471.51	799,614,471.51
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	2,614,950,866.04	2,539,414,644.47

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,847,094,246.00	2,060,912,472.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	69,501,736.00	73,083,472.00
120	Нийтлэг татварын бус орлого	69,501,736.00	73,083,472.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	69,501,736.00	71,424,632.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	69,076,736.00	71,424,632.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /Үндсэн хөрөнгө/	425,000.00	-
120009	Бусад орлого	-	1,658,840.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,777,592,510.00	1,987,829,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,702,551,700.00	1,982,529,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,702,551,700.00	1,982,529,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	75,040,810.00	5,300,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	54,447,110.00	-
131103	ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс	8,000,000.00	5,300,000.00

131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	238,500.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	12,355,200.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	1,902,635,697.60	2,169,899,588.61
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,902,635,697.60	2,169,899,588.61
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,749,507,432.21	2,000,972,394.83
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,084,551,483.15	1,334,256,732.97
210101	Цалин	653,339,142.39	1,051,871,762.94
210102	Нэмэгдэл цалин	256,914,359.76	193,594,135.46
210103	Унаа хоолны хөнгөлөлт	26,252,500.00	24,515,000.00
210104	Урамшуулал	61,096,081.00	64,275,834.57
210105	Гэрээтийн цалин	86,949,400.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	136,558,873.68	166,686,179.62
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	94,663,017.42	114,927,138.00
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	12,493,176.31	12,668,213.67
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	8,064,510.58	10,671,471.88
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	1,920,933.61	2,534,839.97
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	19,417,235.76	25,884,516.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	190,513,260.50	215,381,816.86
210301	Гэрэл цахилгааны зардал	12,333,321.00	17,792,490.86
210302	Түлш, халаалтын зардал	154,810,480.00	179,828,726.00
210303	Цэвэр, бохир усны зардал	23,369,459.50	17,760,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,091,011.92	8,832,370.00
210401	Бичиг хэргийн материал	2,591,200.00	252,500.00
210402	Тээвэр, шатахууны зардал	366,892.00	5,300,000.00
210403	Шуудан холбоо интернетийн төлбөр	3,112,919.92	2,891,270.00
210406	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	20,000.00	388,600.00
2105	Нормативт зардал	83,681,808.00	95,095,404.04
210502	Хоол	82,791,810.00	94,333,404.04
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	889,998.00	762,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,876,200.00	19,688,450.00
210601	Багаж хэрэгсэл	-	412,500.00
210604	Урсгал засвар	2,876,200.00	19,275,950.00
2107	Томилолт, зочны зардал	1,403,000.00	790,600.00
210702	Дотоод томилолтын зардал	1,403,000.00	790,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	9,345,200.00	6,043,330.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,005,200.00	2,643,330.00
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	2,000,000.00	3,400,000.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	2,340,000.00	-

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	234,486,594.96	154,197,511.34
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	72,008,850.00	3,748,900.00
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	45,474,500.00	13,303,450.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	117,003,244.96	137,145,161.34
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	153,128,265.39	168,927,193.78
2132	Бусад урсгал шилжүүлэг	70,520,460.00	97,143,094.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	650,000.00	600,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	37,219,900.00	17,952,800.00
213208	Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	32,650,560.00	78,293,294.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	-	297,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	81,559,405.39	71,784,099.78
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	81,559,405.39	71,784,099.78
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,048,400.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,048,400.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	(55,541,451.60)	(108,987,116.61)
5	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	(55,541,451.60)	(108,987,116.61)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	69,076,736.00	71,424,632.00
120	Нийтлэг татварын бус орлого	69,076,736.00	71,424,632.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	69,076,736.00	71,424,632.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	69,076,736.00	71,424,632.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,840,563,230.00	1,987,829,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,702,551,700.00	1,982,529,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,702,551,700.00	1,982,529,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	138,011,530.00	5,300,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	117,417,830.00	-
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс	8,000,000.00	5,300,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	238,500.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	12,355,200.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	1,795,224,387.00	2,024,632,122.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,795,224,387.00	2,024,632,122.00

210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,642,096,121.61	1,855,704,928.22
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,069,117,832.19	1,357,754,873.52
210101	Үндсэн цалин	637,598,095.86	1,078,917,146.49
210102	Нэмэгдэл	257,221,755.33	212,022,549.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	27,126,594.00	24,536,872.19
210104	Үр дүнгийн урамшуулал	60,221,987.00	42,278,305.84
210105	Гэрээт ажлын хөлс	86,949,400.00	-
2102	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	134,154,154.00	148,120,928.84
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	85,029,058.63	93,452,205.00
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	19,389,585.95	10,011,364.87
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	8,009,988.72	4,885,800.00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	1,968,298.99	1,185,000.00
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	19,757,221.71	38,586,558.97
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	190,508,260.50	215,249,464.10
210301	Гэрэл цахилгааны зардал	12,333,321.00	17,660,138.10
210302	Түлш, халаалтын зардал	154,810,480.00	179,828,726.00
210303	Цэвэр, бохир усны зардал	23,364,459.50	17,760,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,346,699.92	3,109,227.72
210401	Бичиг хэрэг	179,500.00	173,000.00
210402	Тээвэр, шатахуун	366,892.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,967,907.92	2,619,257.72
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,832,400.00	316,970.00
2105	Нормативт зардал	86,139,108.00	91,305,654.04
210502	Хоол, хүнс	82,602,510.00	90,339,654.04
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,536,598.00	966,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,990,200.00	3,581,700.00
210601	Багаж техник хэрэгсэл	-	643,800.00
210604	Урсгал засвар	5,990,200.00	2,937,900.00
2107	Томилолт, зочны зардал	1,403,000.00	790,600.00
210702	Дотоод албан томилолт	1,403,000.00	790,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	35,885,167.00	3,511,680.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	31,400,155.00	1,511,680.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,485,012.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	112,551,700.00	32,280,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	62,997,150.00	8,360,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	49,554,550.00	23,920,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	153,128,265.39	168,927,193.78
2132	Бусад урсгал шилжүүлэг	70,520,460.00	97,143,094.00

213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	650,000.00	600,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	37,219,900.00	17,952,800.00
213208	Хөдөө орон нутагт тогвортой ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	32,650,560.00	78,293,294.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	-	297,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	81,559,405.39	71,784,099.78
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	81,559,405.39	71,784,099.78
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,048,400.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,048,400.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	114,415,579.00	34,621,510.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	114,415,579.00	36,280,350.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	114,415,579.00	36,280,350.00
2200	Дотоод эх үүсвэрээр	114,415,579.00	36,280,350.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	114,415,579.00	36,280,350.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(114,415,579.00)	(36,280,350.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	(1,658,840.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,975,612,137.46	799,614,471.51	-161,550,971.97	2,613,675,637.00
D01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,975,612,137.46	799,614,471.51	-161,550,971.97	2,613,675,637.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0.00	0

D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,975,612,137.46	799,614,471.51	-161,550,971.97	2,613,675,637.00
D08	Тайлант үеийн үр дүн	0	0	-108,987,116.61	-108,987,116.61
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,975,612,137.46	799,614,471.51	-270,538,088.58	2,504,688,520.39

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,989,199,000.00	2,060,912,472.00
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	1,989,199,000.00	2,060,912,472.00
210	Бараа, үйлчилгээний зардал	1,892,309,000.00	1,891,985,278.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,337,607,700.00	1,357,794,777.56
210101	Үндсэн цалин	1,028,403,949.00	1,048,591,026.27
210102	Нэмэгдэл	212,022,549.00	212,022,549.00
210103	Унаа, болон бусад нөхөн олговор	24,536,872.00	24,536,872.19
210104	Урамшуулал	72,644,330.00	72,644,330.10
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	169,951,000.00	148,120,928.84
210201	Тэтгэврийн даатгал	110,606,700.00	93,452,205.00
210202	Тэтгэмжийн даатгал	14,836,200.00	10,011,364.87
210203	ҮОМШӨ ний даатгал	11,868,900.00	4,885,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,967,100.00	1,185,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	29,672,100.00	38,586,558.97
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	216,342,100.00	215,249,464.10
210301	Гэрэл цахилгаан	17,393,200.00	17,660,138.10
210302	Түлш, халаалт	179,828,800.00	179,828,726.00
210303	Цэвэр, бохир ус	19,120,100.00	17,760,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,110,400.00	3,109,227.72
210401	Бичиг хэрэг	154,300.00	173,000.00
210402	Тээвэр (шатахуун)	763,900.00	-
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	608,300.00	2,619,257.72
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	1,583,900.00	316,970.00
2105	Нормативт зардал	94,223,700.00	91,265,750.00
210502	Хоол, хүнс	92,485,600.00	90,299,750.00
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл	1,738,100.00	966,000.00
2106	Эд хогшил худалдан авах	19,896,500.00	19,896,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	16,958,600.00	16,958,600.00
210604	Урсгал засвар	2,937,900.00	2,937,900.00

2107	Томилолт, зочны зардал	790,700.00	790,600.00
210702	Дотоод албан томилолт	790,700.00	790,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	23,894,600.00	23,477,230.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,894,400.00	21,477,230.00
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	2,000,200.00	2,000,000.00
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	26,492,300.00	32,280,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,571,500.00	8,360,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	23,920,800.00	23,920,800.00
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	96,890,000.00	168,927,193.78
2131	Засгийн газар хоорондын шилжүүлэг	-	71,784,099.78
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	71,784,099.78
2132	Бусад урсгал шилжүүлэг	96,890,000.00	97,143,094.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	643,000.00	600,000.00
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,952,800.00	17,952,800.00
213208	Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж	78,294,200.00	78,293,294.00
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	-	297,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,799,823,400.00	2,059,301,792.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,793,153,400.00	1,982,529,000.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,793,153,400.00	1,982,529,000.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	6,670,000.00	71,472,792.00
1200041	Үндсан үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,670,000.00	71,472,792.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	5,300,000.00
131103	ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс зохих байгууллагын шийдвэрийн дагуу тухай төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	5,300,000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	75.00	75.00
620001	Удирдах ажилтан	2.00	2.00
620002	Гүйцэтгэх ажилтан	46.00	46.00
620003	Үйлчлэх ажилтан	27.00	27.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Монгол Улсын Консерваторийн харъяа Завхан аймаг дахь Хөгжим бүжгийн коллеж нь Үйл ажиллагааг оновчтой төлөвлөж хэрэгжүүлэх, ажлын байрны шаардлагад нийцүүлэн мэдлэг чадвараа дээшлүүлэх, төрийн албаны тухай хууль тогтоомж, стандарт, ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, сонирхлын зөрчилгүй ажиллах, байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, төсвийн болон эд хөрөнгийг зохистой ашиглах, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх зэрэг манлайллын зорилтуудыг хангах талаар төсвийн шууд захирагчийн тухайн жилд гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхойлоход оршино.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 14 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 96 хувийн гүйцэтгэлтэй гэж үнэлсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ. Дотоод хяналтын зөвлөл нь 2023 оны ажлын төлөвлөгөөндөө 5 ажил хийхээр төлөвлөсөн байна. Төлөвлөгөөний дагуу хяналт шалгалт бүрд удирдамж батлуулж, хяналтаар илэрсэн зөрчлийг арилгаж ажилласан байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Монгол Улсын Консерваторийн харъяа Завхан аймаг дахь Хөгжим бүжгийн коллежийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Монгол Улсын Консерваторийн харъяа Завхан аймаг дахь Хөгжим бүжгийн коллежийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 75,536.2 мянган төгрөгөөр буюу 9.2 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	11,604.5	16,537.4	4,932.9
Бараа материал	351,010.8	369,866.50	18,855.7
Үндсэн хөрөнгө	2,943,537.90	2,981,358.30	37,820.40
Нийт хөрөнгө	2,614,950.80	2,539,414.60	(75,536.2)
Өр төлбөр	1,275.20	34,726.10	33,450.9
Засгийн газрын хувь оролцоо	2,613,675.60	2,504,688.50	108,987.10
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,614,950.80	2,539,414.60	(75,536.2)

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

Тайланд онд:

Бараа материалын эхний үлдэгдэл 351,010.8 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр 150,487.7 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 131,678.0 мянган төгрөгийн бараа материал зарцуулан, эцсийн үлдэгдэл 369,866.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 18,855.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгийн хувьд төсвийн хөрөнгөөр 37,820.3 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, жилийн эцэст 2,981,358.3 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Тайлант оны элэгдлийн зардалд 137,145.1 мянган төгрөгийг тооцож бүртгэсэн байна.

Богино хугацаат өр төлбөр эхний үлдэгдэл 1,275.2 мянган төгрөг, тайлант онд 2,220,277.6 мянган төгрөгөөр нэмэгдэж, 2,209,363.2 мянган төгрөгөөр хорогдож, 34,726.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Энэ нь бараа үйлчилгээний зардлын өглөг үүссэнтэй холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 108,987.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй шууд холбоотой болно.

5. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,793,153.4 мянган төгрөгөөр, үндсэн үйл ажиллагаанаас 6,670.0 мянган төгрөгөөр төлөвлөж, нийт зарлагыг 1,989,199.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,982,529.0 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлсэн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,982,529.0 мянган төгрөгийг, үндсэн үйл ажилаагаанаас 71,307.6 мянган төгрөгийн төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,053,836.6 мянган төгрөг буюу 103.2 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Хөтөлбөр, арга хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Улсын төсвөөс санхүүжих					
71802	Ерөнхий боловсрол				
80801	Үндсэн үйл ажиллагаа	1,799,059.4	1,865,330.7		114%
81806	Дотуур байрын хүүхдийн хоол	92,485.6	89,981.7		97.2%
81802	Бусад урсгал шилжүүлэг	96,890.0	96,846.1		99.9%
НИЙТ		1,989,199.00	2,053,836.60		103.2%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3. Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр 5,417.0 төгрөгийн орлого төвлөрүүлж, шатахууны зарцуулсан байна.

4. Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2023 онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

5. Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар*/мянган төгрөг/*

№	Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга	Бараа ажил үйлчилгээний нэр	Төлөвлөлт	Гүйцэтгэл
1	Шууд гэрээ байгуулах	Хүүхдийн хоол	92,485.6	89,981.7
2	Шууд гэрээ байгуулах	Түлш халаалт	179,828.8	179,828.7
3	Шууд гэрээ байгуулах	Гэрэл цахилгаан	17,393.2	17,660.1
4	Шууд гэрээ байгуулах	Цэвэр, бохир ус	19,120.1	17,760.6
5	Шууд гэрээ байгуулах	Урсгал засвар	2,937.9	2,937.9
6	Шууд гэрээ байгуулах	Харилцаа холбооны зардал	608.3	2,619.2
7	Шууд гэрээ байгуулах	Сургалтыг дэмжих бусад үйлчилгээ /хичээл үйлдвэрлэл/	23,920.8	23,920.8
8	Шууд гэрээ байгуулах	Багаж, техник, хэрэгсэл	16,958.6	16,958.6
ДҮН			353,253.30	351,667.60

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчил илрээгүй болно.

4. АУДИТЫН ТАЙЛАН**4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Монгол Улсын Консерваторийн харъяа Завхан аймаг дахь Хөгжим бүжгийн коллежийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Ари финайнс аудит” ХХК-ийн гэрээт аудитор Ц.Алтантуул гүйцэтгэж, хяналтыг “Ари финайнс аудит” ХХК-ийн захирал Д.Ариунаа анхан шатанд хянаж, Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсүвд, аудитын менежер Х.Болдбаатар нар хоёр дахь шатанд, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа дараагийн шатанд хяналтыг хэрэгжүүлсэн.

Монгол Улсын Консерваторийн харъяа Завхан аймаг дахь Хөгжим бүжгийн коллежийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Ари финайнс аудит” ХХК-д 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 03 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр

санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны хагас жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 879,800.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 13,197.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 9,897.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзэн, санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас 2,156,161.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 32,341.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 24,256.8 мянган төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 29 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа зөрчил илрээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2023 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Монгол Улсын Консерваторийн харъяа Завхан аймаг дахь Хөгжим бүжгийн коллежийн 2023 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 4,950.0 мянган төгрөгийн зөрчилд 1 заалт зөвлөмж, 11,604.5 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага өгч, 1,200.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосныг хэрэгжүүлэн ажилласан байна.

6. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Монгол Улсын Консерваторийн харъяа Завхан аймаг дахь Хөгжим бүжгийн коллежийн дараа жилийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах асуудлуудыг анхаарч үзэх шаардлагатай байна.Үүнд:

- Үндсэн хөрөнгийн бүртгэл, элэгдэл
- 6-9 дүгээр ангийн суралцагчдаас авдаг сургалтын төлбөр болон төлбөрийн үндэслэлийг анхаарч үзэх албан ёсны шийдвэр,эрх зүйн акт гаргуулж мөрдөх
- Мэргэжлийн ангийн оюутны сургалтын төлбөр болон байрын төлбөр тогтоосон тушаал, шийдвэр
- Төлбөрийн орлогын бүртгэл, орлого хүлээн зөвшөөрөлт

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 868,305,328.67 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 551,993,340.98 мянган төгрөгийн 7 алдааг залруулж, 315,420,678.4 мянган төгрөгийн 8 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 891,309.29 төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 316,311,987.69 төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 292,055,187.69 төгрөгөөр давсан тул Сөрөг дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

552,642 төгрөгийн илүү цагийн нэмэгдэл, 338,667 төгрөгийн үр дүнгийн урамшуулалыг тус тус илүү тооцож олгосонд төлбөрийн акт тогтоолоо.

5.2 Албан шаардлага

Завхан аймаг дахь Монгол Улсын Консерваторийн харъяа Хөгжим бүжгийн коллеж нь 2023 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд 11,604,548.40 төгрөгийн авлагыг тооцооны үлдэгдлийн баталгаагаар баталгаажуулаагүй, 108,363,820 төгрөгийн хөрөнгийн ашиглалтын хугацааг оруулаагүйгээс хөрөнгийн элэгдэл бодогдоогүй, 20,212,955 төгрөгийн хөрөнгийн орлогыг бүртгэхдээ тоо хэмжээ болон үнийн дүнг зөрүүлж бүртгэсэн, 5,300,000 төгрөгийн бараа материалын хөдөлгөөний бүртгэл буруу хийсэн, 72,966,472 төгрөгийн оюутнуудын байрны төлбөр болон сургалтын төлбөрийг Удирдах зөвлөлөөр тогтоолгоогүй, хүчингүй тогтоолоор төлүүлж, орлого хүлээн зөвшөөрөлтийг нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт заасны дагуу хийж, хүлээн зөвшөөрдөггүй, 7,980,000 төгрөгийн суралцагчдын баруун аймгуудаар явсан тайлан тоглолтын орлогыг санхүүгийн тайланд тусгаагүй, хувь хүний дансаар дамжуулан зарцуулсан, 72,177,883 төгрөгийн үр дүнгийн урамшууллыг захирлын тушаалыг хавсралтгүйгээр гаргаж олгосон, 16,815,000 төгрөгийн улирлын үр дүнгийн урамшууллыг шийдвэргүйгээр олгосон зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

5.3 Зөвлөмж өгөгдөөгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/


Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Орлого буруу бүртгэсэн	1	72,966.4			1	72,966.47			1	72,966.47		
Авлага тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй	1	11,604.5			1	11,604.55			1	11,604.55		
2022 оны сард үндсэн хөрөнгө орлого авахдаа ашиглах жил сонгоогүй орлого авсан	1	108,363.8			1	108,363.82			1	108,363.82		
Үндсэн хөрөнгө орлого авахдаа тоо хэмжээ, нэг бүрийн үнэ сольж авсан	1	20,212.9			1	20,212.95			1	20,212.95		
Тушаалын хавсралтгүйгээр олгосон үр дүнгийн урамшуулал 1,2, 3, 4 улиралд	1	72,177.8			1	72,177.88			1	72,177.88		
Тушаал шийдвэргүйгээр олгосон 3-р хагасын цалин	1	16,815.0			1	16,815.0			1	16,815.0		
Тоглолтын орлого зарлага бэлэн мөнгөнийн гүйлгээний тайлан бэлтгээгүй.	1	7,980.0			1	7,980.0			1	7,980.0		
Шатахууны баримтгүй	1	5,300.0			1	5,300.0			1	5,300.0		
Илүү цаг үр дүнгийн урамшуулал илүү тооцож олгосон	1	891.3	1	891.3								
Дүн	1	316,311.70	1	891.3	8	315,420.67			8	315,420.67		

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Д.БАТ-УНДРАА

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР  Х.БОЛДБААТАР

АХЛАХ АУДИТОР  Ц.ОЮУНСУВД

АРИ ФИНАЙНС АУДИТ ХХК-ИЙН

ГЭРЭЭТ АУДИТОР  Ц.АЛТАНТУУЛ

Огноо: 2024-02-23